

Coming to terms with Buddhism

“Шашинд хөтлөн оруулах”

~буюу аз жаргалтай болох ойрын зам~

РКК-д “ном унших”, “Шашинд хөтлөн оруулах, хоза”, “Сургаал суралцах” гэсэн гурван том чухал даяан байдаг. Ном уншлагын талаар өмнөх дугаарт ярьсан билээ. Энэ дугаартаа та бүхэнд “шашинд хөтлөн оруулах” тухай ярья.

РКК-ийн “мичибик” буюу “шашинд хөтлөн оруулах” үйл ажиллагаа нь бол орчин тойрныхоо хүмүүст Буддын сургаалыг түгээж, биелүүлэх явдалд оршдог байна.

Гэнэт асууя л даа. Та бүгдэд одоо ямар нэгэн зовлон гачигдал бий юу? Эсвэл өөрийгөө ийм тийм болгохсон гэсэн хүсэл мөрөөдөл бий юу? Ийм үед РКК нь та бүгдэд “мичибик”-г зөвлөдөг юм. Өөрөө зовон шаналж байх үедээ хэн нэгний тухай санаа тавина. Хачин санагдах боловч энэ бол манай нийгэмлэгийн зан чанар юм.


Яагаад гэвэл хүн өөр хүний зовлон гачигдалыг тайлах гэж оролдох үед тэдгээр асуудлууд нь өөрийн асуудалтай их төстэй байдаг гэдгийг анзаарана. Ийнхүү хүний төлөө санаа зовж байх үед өөрийгөө ч илүү сайн ойлгож эхэлдэг байна. Хүнд дамжуулах гэсэн сургаал нь үнэндээ яг өөрт нь таарсан байдаг юм.

Мөн буддын сургаалд бүх зүйл тогтворгүй гэдэг. Энэ нь энэ хорвоогийн бүх зүйлс нь ганцаар оршин тогтнох чадваргүй бөгөөд бүгд хоорондоо уялдаа холбоотой байдаг гэсэн утга юм. Харахад өөрт ямар ч хамаагүй гадны хүн ч гэсэн Буддын нүдээр

“12 Messages”-н оронд энэ сараас эхлэн [Coming to terms with Buddhism] гэсэн шинэ дугаараа эхэллээ. Үүнээс хойш 12 удаа хувааж РКК-ийн нандигнан хайрладаг 6 даяан ба 6 үгийг танилцуулах болно.

харвал өөрт учир холбогдолтой хүн болж харагддаг байна.

Ямар нэгэн зовлонтой хүн. Ийм болохсон гэсэн хүсэл мөрөөдөлтэй хүн. Та бүгд худлаа гэж бодонгоо ч гэсэн өөрийнхөө төлөө биш хэн нэгний төлөө санаа зовж үзвэл хэрхэн бэ? Энэ бол тэр хүн ч, та өөрөө ч аз жаргалд хүрэх хамгийн ойр зам болж магадгүй юм.



Information from Hawaii!!

Буддын хөргийг хийх жааз бэлэн боллоо. Гавай аралын мэргэжилтэн тус бүрийн жаазыг гар хийцээр хичээнгүйлэн бүтээсэн эдгээр жаазны бүрдэл нь 100 долларын үнэтэй. Мэдээж хэрэг нэг нэгээр нь худалдан авч болно. Гавай аралын үндэсний маягаар хийсэн модон энэ жаазнууд нь дулаахан үзэмжтэй бөгөөд коа мод ба чэрри модоор хийсэн хоёр сонголттой. Буддын өлмий дор нь жижигхэн хөөрхөн лянхуа цэцэгтэй энэ жааз нь гүнгэрвааг зөөлөн сайхан уур амьсгалтай болгоно. Тодорхой мэдээлэл хүссэн хүн Гавайн нийгэмлэгийн Роланд Фүжий гуайтай холбогдоорой. Интэрнэт вэб хуудас нь:

Say it with Koa ([http:// sayitwithkoa.com](http://sayitwithkoa.com))

Дэлгэрэнгүй мэдээлэлийг эндээс асуу!
info@savitwithkoa.com



Хэвшмэл зан үйл нь сэтгэлийг өсгөн хөгжүүлдэг

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч
Нивано Ничикоу

Нэгэн дэс дараалалттай амьдрал

Зөв дэс дараатай амьдрал нь эрүүл ахуйн үндэс гэдэг билээ.Зав чөлөөгүй орчин үеийн хүн хоол унд,нойроо хасах явдал цөөнгүй боловч нэгэн дэс дараа зохиож,түүнийхээ дагуу амьдарч чадах боломжтой билээ.Энэ дэс дараанд дасвал эхлээд сэтгэл дотроо эсэргүүцэж байсан бол яваандаа энэ нь эсрэгээр сайхан санагдаж эхлэх тул үнэхээр сонин шүү.

Манай нийгэмлэгийн нэгэн дүрэм бол “судар унших”явдал билээ.Өглөө босонгуутаа гүнгэрвааныхаа дэргэд бурхандаа цай идээгээ тавьж,судраа уншина-ингэж нэгэн шинэ өдөр эхэлж,амьдралын дэс дараа бүрэлдэнэ.Сэтгэл санаа ч сайхан тайвшрана.

Өглөөгүүр завгүй гэдэг хүн байдаг боловч судраа унших цагийг бүтээх хэрэгтэй юм.

Үндсэндээ бол судрыг бүхлээр нь унших хэрэгтэй боловч зөвхөн нэг бүлэг унших юм уу,эсвэл ядаж алгаа хавсруулан мөргөж ч болно.

Энэ нь нэгэн өдрийн хэвшмэл зан үйл болтол эхлээд зөвхөн хэв маягийн төдийгөөр хийж болно.Яваандаа өөрийн сэтгэл санаа,үзэл бодол өөрчлөгдөхийг мэдрэх болно.Тийм болбол аливаа зүйлд хандах хандлага ч өөрчлөгдөх тул өөрийн орчин тойрны байдал ч мөн өөрчлөгдөж эхлэнэ.

Гурван дадлага хэрэгжүүлэлт

Энэ нь зөвхөн судар унших явдлаар хязгаарлагдахгүй.Хэвшмэл зан үйлтэй болсноор аж амьдрал тэр чигээрээ өөрчлөгдөж эхлэнэ.

Хүнтэй сайхан инээмсэглэж мэндлэнэ,хүн дуудвал цоглог хариу өгнө,тайлсан гутлаа засаж тавина-гэсэн бидний үндсэн гурван хэвшмэл зан үйл бол зөвхөн сайн хэвшмэл үйлээр барахгүй хүний харилцаа холбоог элбэг дэлбэг болгох чадалтай зүйл юм.Мэндлэх,хариулах,гутлаа засах гэсэн үйлийг “Яагаад ингэх хэрэгтэй юм бэ?”гэж бодож магадгүй.Гэвч эдгээрийг хэрэгжүүлж ирснээр ганц



мэндлэх үйлийг ч гэсэн чин сэтгэлээсээ,сэргэлэн цовоогоор хийж чаддаг болно.Ингэснээр орчин тойрон ч өөрийн эрхгүй амгалан тайван болно.

Одоогоо хайрлах

Нэгэн кампаний захирал нь үе үе ажилчидтайгаа хамт нийлж жорлонгоо цэвэрлэдэг гэсэн.Шинээр орсон залуу ажилчид эхлээд дургүйцэж цэвэрлэдэг байсан бол яваандаа аливаа зүйлд чин сэтгэлээсээ хандах байдлын баяр баясгаланг мэдэрч,өчүүхэн зүйлд ч гэсэн талархаж сурсан гэсэн.

Мөн бүтээгдэхүүн бүтээдэг ажлын газарт дэс дараа,цэвэрлэгээны ажлыг сайжруулснаар ажлын нийт үр бүтээлд сайнаар нөлөөлсөн гэсэн яриа ч байдаг.

Энэ бол сая өгүүлсэн судар унших хэвшмэл заны адил аливаа зүйлийг дэс дараатай,хэвшмэл хийх явдлаар үүнийг дагаж,сэтгэл санаа ч жигдрэн хөгждөг гэсэн үг юм.

Энэ сар бол Шагжамүнигийн таалал өгсөн сар билээ.Шагжамүнигийн сүүлийн үг нь “Бүх зүйлс өөрчлөгдөн явдаг.Залхууралгүй хичээцгээ”гэсэн үг байсан гэдэг.

Энэ нь Хязгааргүйн хуулийн дагуу амьдардаг бид нарт одоо нүдний өмнө байгаа хүнээ,байгаа зүйлээ хайрлаж,одоог,өнөөдрийг хайрла гэсэн сургаал юм.Шагжамүнигийн хэлсний дагуу бид өнөөдрөө,одоо байгаа амьдралаа хайрлаж явцгаая.

Израил Палестины эв найрамдлын төлөө

Рисшо Косей Кай дэд ерөнхийлөгч ватанабэ ясутака

Израил, Палестины асуудал хямралын байдалд ороод байгаа билээ. 2 талын цэргийн хүчний үл ойлголцолд хандан НҮБ-ын аюулгүй байдлыг батлаг хамгаалах газраас авхуулаад бусад байгууллагууд, улс орнууд дайнаа зогсоохыг уриалж байгаа хэдий ч огтхон ч дайнаа зогсоох шинж ажиглагдахгүй байна.

Рисшо Косей Кай нь өнөөг хүртэл WCRP буюу дэлхийн шашны энх тайвны хурлаар дамжуулан Израил, Палестины асуудалд анхаарлаа хандуулж тус орны шашны байгууллагатай зөвлөлдөн, холбоо тогтоож ирсэн билээ. Мөн түүнчлэн Рисшо Косей Кай нь Нэг хоол энх тайвны фонд, Нивано энх тайвны фонд, “Мөрөөдлийн хайрцаг” зэрэг үйл ажиллагаагаараа дамжуулан тус оронд энх тайвныг бий болгоход хувь нэмэрээ оруулж байгаа билээ. Ард иргэд болон тайван бус байдалд байгаа хүүхдүүдэд нь ч гэсэн тусламж үзүүлсээр байна. 2 улсын иргэд үнэн хэрэгтээ дэлхийн ард иргэд зэрэгцэн орших явдлыг эрэлхийлж буй бодит байдалтай санаа нэгдэж, асуудлыг шийдвэрлэх томоохон боломж байгааг мэдэрч байгаа юм.

Энэхүү цэргийн хүчний сөргөлдөөн нь тэдгээр хүмүүсийн хүсэл эрмэлзлэлийн эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа хэрэг бөгөөд улс төрийн шинжтэй сөргөлдөөн, янз бүрийн буруу үзлийн улмаас үүссэн биз ээ. Мөргөлдөөний улмаас амь насаа алдсан хохирогч нарт гүн хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээгээр дарангуйллын шинжтэй үйл ажиллагаагаа зогсоон, тайван замаар хэлэлцээр хийн асуудлыг шийдвэрлэх замыг сонгохыг туйлын ихээр хүсэж байна.

20-р зууныг “Дайны жил” гэж нэрлэдэг. 21-р зуунд дэлхийн хүн төрөлхтөн “Зэрэгцэн орших нийгэм”-ийг байгуулъя хэмээн харилцан амлалт өгөөд байгаа билээ. Гэвч ойрын жилүүдэд ч Израил, Палестины мөргөлдөөнөөс авхуулаад Африк, Афганистан, Төвд, Шриланк, Филиппин, Ирак зэрэг олон орон, бүс нутагт дайн байлдаан үргэлжилсээр байна. Өмнөх зууны “Дайны ялагдлын үлдэгдэл”-ийг бүрэн арилгах боломжгүй юм. Энэ бодит байдал нь хүн төрөлхтний оюун сэтгэл болоод үйлдэл огтхон ч өөрчлөгдөөгүй байгааг тодхон харуулж байгаа мэт санагдана.

Шашин нь “хүмүүс бид бүгд угаасаа л яг ижил чанартай, тиймээс уужим сэтгэлээр бие биенээ харилцан хүлээн зөвшөөрч, бие биедээ туслъя” гэсэн Их Хөлгөний үндсэн ухагдахууныг сургадаг юм. Мөн “Тайван амгалан сэтгэл” гэдэг нь хүн болж төрснийхөө сайхныг, баярлууштайг, мөн гайхалтайг мэдэрч, улмаар бусад хамаг амьтны амь насыг хайрлан хүндэтгэх сэтгэлийг хэлнэ хэмээн сургадаг билээ.

Үүний тулд уурлан бухимдах сэтгэлээ ялан дийлж, хайр, энэрэл, сайхан сэтгэлийг бий болгох нь нэн чухал юм. Ингэснээр хүмүүс харилцан ойлгоцож чадна гэдэгт итгэлтэй байна.

Шашины үүднээс харвал дэлхий нийтийн асуудал бол миний биед ч хамаатай асуудал юм. Рисшо Косей Кай нь WCRP-ын гишүүний хувьд Израил, Палестины асуудлыг шийдвэрлэхийг зорин дэлхийн шашны байгууллагуудтай хамтран ажиллах болно. Үүний зэрэгцээгээр бидний зүрх сэтгэл дотор ч гэсэн “дайны үр” байхгүй эсэхийг сайн нягталж, хүн бүхэн чин сэтгэлээсээ “энх тайвныг дээдлэдэг хүн” болохын төлөө бурхны үйлд шамдан суралцацгаая. Дэлхийд гарч буй мөргөлдөөн нэг хором ч болов эрт дуусах болтугай, уйтгар гунигт автаж, хүсэл мөрөөдлөө алдсан хүмүүст гэрэл гэгээ ирэх болтугай хэмээн нийгэмлэгийнхээ гишүүдийн өмнөөс чин сэтгэлээсээ мөргөн залбирч байна.



Италийн нэгэн гишүүний хувьд

Никола Тини



Би 2007 оны 10 сарын 2-с гурван долоо хоногоор Японд сургалтаар явсан юм.Төв дээр хичээлд оролцсоноор би РКК-ийн сургаал бол амьдрал дээр хэрэгжүүлдэг сургаал гэдгийг мэдэрч,бас шашны хамтарсан үйл ажиллагаа бол Нэгэн Хөлгийн шашны жинхэнэ илрэл мөн гэдгийг ойлгосон.

Би анх буддын сургаалтай оюутан байсан 1992 онд учирсан юм.Европд бол буддын шашин гэхлээр голцуу зэн урсгалыг дүрсэлдэг боловч би анх Лянхуа Цэцгийн судрын уншлагыг сонсоод сэтгэл ихэд цочрон хөдөлсөн юм.

Өдрийн 24 цаг Буддатай хамт байхсан гэсэн хүсэлтэйгээр би нэг жилийн даяан хийсний дараа Кобэ хотод даяан хийхээр явсан билээ.Ийнхүү би Буддатай учрах боломжтой болсон боловч сэтгэл дотроо хүнийг аврахын тулд гэртээ ч гадаа ч сургаалыг тахиж болно гэдгийг ухаарсан юм.

Тэгж байх үед Рома хотын Японы соёлын ордонд “Лянхуа Цэцгийн сургаалын шинэ тайлбар”(Нивано Никкё) 『Rissho Kosei-kai』 (Косэй хэвлэл) гэсэн номтой учирч,сэтгэл санаа маань тэр номонд тэр чигээрээ татагдаж орхисон билээ.Уг номонд Үндэслэгч орчин үеийн хүнд Цагаан Лянхуа Цэцгийн сургаалын утга учир,ашиглалтын талаар энгийнээр тайлбарласан байсан.

Тэгээд би Токиогийн Төв үрүү “Танай сургаалыг суралцмаар байна.Ромад намайг хөглөн оруулах хүн бий юу?”гэсэн захиа явуулсан юм.Тэгтэл 2 долоо хоногийн дараа хариу нь ирж,Рома хотын Григорио Их Сургуульд суралцаж байсан Кавамото гуайг танилцуулсан билээ.Ийнхүү 1995 онд би анх Косэйкайгийн гишүүны замыг туулж эхэлсэн юм.Би Цагаан Лянхуа Цэцгийн сургаалын дотор “Бүх хүнд бурханлаг мөн чанар байдаг”,”Будда бол Мөнхийн Амь мөн”,”Бодисадвагийн үйл хийснээр хэзээд ч Буддаг мэдэрч чадна”гэсэн сургаалд их дуртай.Одоо бол би сургаалаа гэртээ тахиж,зовж зүдэрсэн хүмүүст авралын замыг нь олж өгөхөд тус нэмэр болох гэж өдөр бүр хичээж байгаа.

Италид бол одоохондоо Косэйкайгийн салбар байхгүй.Зорилго бол хэзээ нэгэн цагт Ромад сангагийн хүрээг нээх явдал билээ.Бас вэб хуудас хийж,итали хэл дээр судрыг орчуулах хүсэлтэй.Энэ удаад намайг сайхан хүлээн авч,олон зүйл зааж сургаж өгсөн японы сангагийн гишүүдийг дуурайж би ч мөн Рома хотдоо сургаалыг түгээн тараахыг хичээнэ



